



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

2025 оны гуравдугаар улирал



Улаанбаатар хот 2025 он



ГЭМТ ХЭРЭГ

Сонгинохайрхан дүүрэг нь 96524 өрхийн 343439 хүн амтай бөгөөд 2025 оны гуравдугаар улиралын байдлаар дүүргийн хэмжээнд 3512 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 688(24.4%) хэргээр өссөн байна.


Тайлант хугацаанд гарсан нийт гэмт хэргийн 2431(85.2%) нь хөнгөн, 521(14.8%) нь хүнд гэмт хэрэг эзэлж байна. Гэмт хэргийн ангилалыг өмнөх онтой харьцуулбал хөнгөн 560(23.0%) гэмт хэргээр, хүнд 128(32.6%) гэмт хэргээр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 1. БҮРТГЭГДСЭН ХЭРГИЙН ТОО жил бүрийн эхний 9 сард

Үзүүлэлт	Бүх гэмт хэрэг			Гэмт хэргийн ангилал					
				Хөнгөн			Хүнд		
	2024.IX	2025.IX	Өсөлт, бууралт %	2024.IX	2025.IX	Өсөлт, бууралт %	2024.IX	2025.IX	Өсөлт, бууралт %
I хэлтэс	1 420	1 256	-11.5	1 215	1 017	-16.3	205	239	16.6
II хэлтэс	722	1 116	54.6	606	938	54.8	116	178	53.4
III хэлтэс	682	1 140	67.2	610	1 036	69.8	72	104	44.4
Нийт дүн	2 824	3 512	24.4	2 431	2 991	23.0	393	521	32.6

2025 оны 3 дугаар улиралын байдлаар бүртгэгдсэн нийт хэргийн 1256(35.8%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 1116(31.8%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 1140(32.4%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст харъяалагдаж байна.

ЗУРАГ 1. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛД АВТСАН ХОХИРОГЧИЙН ТОО, дүүргээр



Тайлант хугацаанд Сонгинохайрхан дүүрэгт гэр бүлийн х үчирхийлэлд автсан хохирогч 71 байгаа нь өмнөх оны мөн үеэс 12(14.5%) хүнээр буурсан байна. Нийслэлд нийт гэр бүлийн хүчирхийлэлд автсан хохирогчийн 71(14.1%) нь сонгинохайрхан дүүргийнх байна.


2025 оны гуравдугаар улиралд нийслэл хотод нийт 26679 хэрэг бүртгэгдсэний 3512(13.2%) гэмт хэрэг Сонгинохайрхан дүүрэгт ногдож байна. Нийслэл хотод гарсан нийт хэргийн 23996(89.9%) хөнгөн гэмт хэрэг, 2683(10.1%) хүнд гэмт хэрэг байна. Нийслэлд гарсан нийт хөнгөн гэмт хэргийн 2991(12.5%), хүнд гэмт хэргийн 521(19.4%) хувь нь тус дүүрэгт ногдож байна.

ХҮСНЭГТ 2. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО, дүүргээр, сараар

Дүүрэг	Бүх хэрэг			Гэмт хэргийн ангилал					
				Хөнгөн			Хүнд		
	2024.IX	2025.IX	Өсөлт, бууралт %	2024.IX	2025.IX	Өсөлт, бууралт %	2024.IX	2025.IX	Өсөлт, бууралт %
Нийслэл	22 941	26 679	16.3	20 850	23 996	15.1	2 091	2 683	28.3
Баянгол	3 640	4 273	17.4	3 404	4 059	19.2	236	214	-9.3
Баянзүрх	6 692	6 890	3.0	6 139	6 235	1.6	553	655	18.4
Сүхбаатар	3 389	3 846	13.5	3 140	3 499	11.4	249	347	39.4
Сонгинохайрхан	2 824	3 512	24.4	2 431	2 991	23.0	393	521	32.6
Хан-уул	3 521	4 492	27.6	3 223	4 069	26.2	298	423	41.9
Чингэлтэй	2 378	3 138	32.0	2 108	2 772	31.5	270	366	35.6
Багануур	226	281	24.3	190	192	1.1	36	89	2.5 дахин их
Багахангай	14	25	78.6	12	15	25.0	2	10	5 дахин их
Налайх	257	222	-13.6	203	164	-19.2	54	58	7.4

2025 оны гуравдугаар улиралд нийслэл хотод 26679 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 3738(16.3%) хэргээр өссөн байна. Нийт гарсан хэргийн 4273(16.0%) нь Баянгол, 6890(25.8%) нь Баянзүрх, 3846(14.4%) нь Сүхбаатар, 3512(13.2%) нь Сонгинохайрхан, 4492(16.8%) нь Хан-уул, 3138(11.8%) нь Чингэлтэй, 281(1.1%) нь Багануур, 25(0.1%) нь Багахангай, 222(0.8%) нь Налайх дүүрэгт тус тус гарсан байна.

ЗУРАГ 2. ГЭМТ ХЭРГИЙН ТОО, дүүргээр



ХҮСНЭГТ 3.

БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО, ХЭРГИЙН АНГИЛЛААР

Үзүүлэлт	Он	хүний амьд явах эрхийн эсрэг	Хүнийг алах	хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох	хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах	хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах	гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	хүний бэлгийг эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	хүчиндэх
Сонгинохайрхан	2024.IX	69	18	46	4	796	33	660	8	71	55
I хэлтэс		31	12	17	2	452	16	374	5	36	28
II хэлтэс		32	5	26	1	191	7	160	1	25	19
III хэлтэс		6	1	3	1	153	10	126	2	10	8
Сонгинохайрхан	2025.IX	90	11	72	4	686	44	562	7	74	59
I хэлтэс		46	3	38	3	344	19	290	1	40	31
II хэлтэс		30	5	24	0	197	12	156	5	23	19
III хэлтэс		14	3	10	1	145	13	116	1	11	9
2025/2024		130.4	61.1	156.5	100.0	86.2	133.3	85.2	87.5	104.2	107.3

2025 оны гуравдугаар улиралд Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн нийт хэргийн 90(2.6%) нь хүний амьд явах эрхийн эсрэг, 686(19.5%) нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 74(2.1%) нь хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг, 25(0.7%) нь хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг, 14(0.4%) нь эдийн засгийн, 92(2.6%) нь олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхолын эсрэг, 7(0.2%) нь хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг, 14(0.4%) нь нийтийн албаны ашиг сонирхолын эсрэг, 14(0.4%) нь хүрээлэн байгаа байгаль орчны эсрэг, 41(1.2%) нь Кибер аюулгүй байдлын эсрэг, 1(0.03%) нь хүүхдийн эсрэг, 258(7.3%) нь хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслэлийн ашиглалтын журмын эсрэг хэргүүд байна.


ХҮСНЭГТ 3.

ҮРГЭЛЖЛЭЛ

Үзүүлэлт	Он	хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг	хүүхдийн эсрэг	эдийн засгийн	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхолын эсрэг	Мансууруулах эм, сэтгэгдэл нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах	хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг	нийтийн албаны ашиг сонирхолын эсрэг	хүрээлэн байгаа байгаль орчны эсрэг	Кибер аюулгүй байдлын эсрэг	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслэлийн ашиглалтын журмын эсрэг
Сонгинохайрхан	2024.IX	17	4	14	27	15	1	13	13	17	149
I хэлтэс		14	3	7	14	9	1	6	12	5	83
II хэлтэс		2	1	2	7	3		5	1	6	42
III хэлтэс		1		5	6	3		2		6	24
Сонгинохайрхан	2025.IX	25	1	14	92	26	7	14	14	41	258
I хэлтэс		18	1	7	35	14	4	8	13	15	156
II хэлтэс		2		3	25	7	2	5		13	60
III хэлтэс		5		4	32	5	1	1	1	13	42
Өсөлт, бууралт хувь		47.1	25.0	100	3 дахин	173.3	7 дахин	7.7	7.7	2 дахин	73.2

2025 оны гуравдугаар улирлын байдлаар өмчлөх эрхийн эсрэг хэрэг 2189(62.3%) гарсан нь өмнөх оны мөн үеэс 559(34.3%) хэргээр өссөн байна.Тайлант хугацаанд нийт өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 578(26.4%) нь хулгайлах гэмт хэрэг, 120(5.5%) нь дээрэмдэх, 1242(56.7%) нь залилах, 37(1.7%) нь хөрөнгө завших, 84(3.8%) нь эд хөрөнгө устгах гэмтээх, 16(0.3%) нь мал хулгайлах хэрэг байна. Хулгайлах гэмт хэргийн 383(66.3%) нь хувийн өмч хулгайлах, 55(9.5%) нь халаасны хулгайн гэмт хэрэг байна. Хувийн өмч хулгайлах гэмт хэргийн 36(9.4%) нь автотээврийн хэрэгслэл хулгайлах гэмт хэрэг байна. Оны сүүлийн 9 сард бүртгэгдсэн нийт хулгайлах гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 49(7.8%) хэргээр буурсан байна. Харин дээрэм 41(51.9%), залилах гэмт хэрэг 546(78.4%), эд хөрөнгө устгах, гэмтээх 8(6.3%) гэмт хэргээр тус тус өссөн байна.

ЗУРАГ 3. ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДСЭН БАЙДЛААР, дүүргээр




ХҮСНЭГТ 4. ӨМЧЛӨХ ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ТОО, төрлөөр

Үзүүлэлт	Он	Өмчлөх эрхийн эсрэг									
		Өмчлөх эрхийн эсрэг	Хулгайлах				Дээрэмдэх	Залилах	Хөрөнгө завших	эд хөрөнгө устгах, гэмтээх	мал хулгайлах
			Хулгайлах	Хувийн өмч хулгайлах	Автотээврийн хэрэгслэл хулгайлах	Халаасны хулгай					
Сонгинохайрхан	2024.IX	1630	627	395	34	60	79	696	35	79	6
I хэлтэс		753	305	182	14	26	19	317	20	40	6
II хэлтэс		408	147	108	9	3	24	180	11	17	
III хэлтэс		469	175	105	11	31	36	199	4	22	
Сонгинохайрхан	2025.IX	2189	578	383	36	55	120	1242	37	84	6
I хэлтэс		565	173	92	18	19	35	240	23	43	6
II хэлтэс		756	174	126	3	4	17	506	5	21	
III хэлтэс		868	231	165	15	32	68	496	9	20	
Өсөлт, бууралт хувь		34.3	-7.8	-3.0	5.9	-8.3	51.9	78.4	5.7	6.3	0.0

Тайлант хугацаанд гарсан өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 565(25.8%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 756(34.5%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 868(39.7%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст тус тус харъяалагдаж байна.

ЗУРАГ 4. ӨМЧЛӨХ ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ, дүүргээр



2025 оны гуравдугаар улирлын байдлаар Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн нийт хэргийн 560(15.9%) нь Даваа гарагт, 543(15.5%) нь Мягмар гарагт, 528(15.0%) нь Лхагва гарагт, 531(15.1%) нь Пүрэв гарагт, 511(14.6%) нь Баасан гарагт, 412(11.7%) нь Бямба гарагт, 427(12.2%) нь Ням гарагт тус тус гарсан байна. Даваа гарагт хамгийн их хэрэг гарсан бөгөөд Бямба, Ням гарагт хамгийн бага хэрэг гарчээ. Гарсан гэмт хэргийн тоог өмнөх оны мөн үетэй харьцуулбал Даваа гарагт гарсан хэрэг 221(65.2%), Мягмар гарагт гарсан хэрэг 117(27.5%), Лхагва гарагт гарсан хэрэг 81(18.1%), Пүрэв гарагт гарсан хэрэг 134(33.8%), Баасан гарагт гарсан хэрэг 96(23.1%), Бямба гарагт гарсан хэрэг 6.064(18.4%), Ням гарагт гарсан хэрэг 75(21.3%) гэмт хэргээр тус тус нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 5. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО, ХЭРЭГ ҮЙЛДЭГДСЭН ГАРАГААР

Үзүүлэлт	Он	Гараг						
		Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням
Сонгинохайрхан	2024.IX	339	426	447	397	415	348	352
I хэлтэс		238	221	228	188	204	187	154
II хэлтэс		90	110	115	104	110	86	107
III хэлтэс		11	95	104	105	101	75	91
Сонгинохайрхан	2025.IX	560	543	528	531	511	412	427
I хэлтэс		206	197	178	187	187	156	145
II хэлтэс		169	168	174	183	162	107	153
III хэлтэс		185	178	176	161	162	149	129
Өсөлт, бууралт хувь		65.2	27.5	18.1	33.8	23.1	18.4	21.3

Тайлант хугацаанд бүртгэгдсэн гэмт хэргийн 1302(37.1%) нь 06-14 цагийн хооронд, 965(27.5%) нь 14-19 цагийн хооронд, 504(14.4%) нь 19-22 цагийн хооронд, 741(21.1%) нь 22-06 цагийн хооронд тус тус гарсан байна. Тайлант хугацаанд гарсан хэргийн байдлаас харахад 06-14 цагийн хооронд хамгийн их хэрэг гарсан бол 19-22 цагийн хооронд хамгийн бага хэрэг гарсан байна. 06-14 цагийн хооронд гарсан гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 459(54.4%) гэмт хэргээр нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 6. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО, ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДСЭН ЦАГААР

Үзүүлэлт	Он	Цаг			
		06-14	14-19	19-22	22-06
Сонгинохайрхан	2024.IX	843	817	493	671
I хэлтэс		316	413	288	403
II хэлтэс		260	196	131	135
III хэлтэс		267	208	74	133
Сонгинохайрхан	2025.IX	1302	965	504	741
I хэлтэс		347	349	218	342
II хэлтэс		469	287	155	205
III хэлтэс		486	329	131	194
Өсөлт, бууралт хувь		54.4	18.1	2.2	10.4

2025 оны сүүлийн 9 сард бүртгэгдсэн нийт хэргийн 1299(37.0%) нь гэр орон сууцанд гарсан хэрэг бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 268(26.0%) хэргээр өссөн байна. Тайлант хугацаанд нийт гэр орон сууцанд гарсан хэргийн 450(34.6%) нь гэрт, 456(35.1%) нь орон сууцны байранд, 229(17.6%) нь хувийн байшинд, 51(3.9%) нь зуслангийн байшинд, 28(2.2%) нь нийтийн байранд, 11(0.8%) нь орцонд тус тус гарсан байна.

Тайлант хугацаанд нийт гэр, орон сууцанд гарсан хэргийн 411(31.6%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 410(31.6%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 478(36.8%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст тус тус бүртгэгдсэн байна.

ХҮСНЭГТ 7. ГЭР, ОРОН СУУЦАНД ҮЙЛДЭГДСЭН ХЭРЭГ

Үзүүлэлт	Он	гэр, орон сууц						
			гэр	орон сууцны байр	хувийн байшин	зуслангийн байшин	нийтийн байр	орц
Сонгинохайрхан	2024.IX	1031	443	251	188	26	21	12
I хэлтэс		522	256	106	92	21	7	2
II хэлтэс		303	138	42	65	4	7	2
III хэлтэс		206	49	103	31	1	7	8
Сонгинохайрхан	2025.IX	1299	450	456	229	51	28	11
I хэлтэс		411	195	86	77	14	5	2
II хэлтэс		410	180	65	102	36	6	2
III хэлтэс		478	75	305	50	1	17	7
Өсөлт, бууралт хувь		26.0	1.6	81.7	21.8	96.2	33.3	-8.3

Тайлант оны сүүлийн 9 сард гудамж тайлбайд 929 хэрэг гарсан нь Сонгинохайрхан дүүрэгт гарсан нийт хэргийн 26.4 хувь болж байна. Тайлант хугацаанд гудамж тайлбайд гарсан нийт хэргийн 398(42.8%) нь гэр хорооллын гудамжинд, 246(26.5%) нь орон сууцны гудамжинд, 98(10.5%) нь ил зогсоол дээр, 78(8.4%) нь автобусын буудал дээр тус тус гарсан байна. Тайлант хугацаанд гудамж талбайд гарсан хэрэг өмнөх оны мөн үеэс 236(34.1%) хэргээр өссөн бөгөөд нийт гудамж, талбайд гарсан хэргийн 241(25.9%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 377(40.6%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 311(33.5%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст тус тус бүртгэгдсэн байна.

ХҮСНЭГТ 8. ГУДАМЖ, ТАЛБАЙД ҮЙЛДЭГДСЭН ХЭРЭГ

Үзүүлэлт	Он	Гудамж, талбай	гэр хорооллын гудамж	орон сууцны хороололын гудамж	ил зогсоол	автобусны буудал
Сонгинохайрхан	2024.IX	693	248	168	91	66
I хэлтэс		255	101	40	24	24
II хэлтэс		189	107	21	19	21
III хэлтэс		249	40	107	48	21
Сонгинохайрхан	2025.IX	929	398	246	98	78
I хэлтэс		241	89	57	22	21
II хэлтэс		377	273	38	14	26
III хэлтэс		311	36	151	62	31
Өсөлт, бууралт хувь		34.1	60.5	46.4	7.7	18.2

2025 оны сүүлийн 9 сард олон нийтийн газарт 273 хэрэг бүртгэгдсэн нь нийт хэргийн 7.8 хувийг эзэлж байгаа бөгөөд олон нийтийн газарт гарсан нийт хэргийн 57(20.9%) нь дэлгүүрт, 38(13.9%) нь зочид буудалд, 40(14.7%) нь бааранд, 10(3.6%) нь ресторан зоогийн газарт, тус тус гарсан байна. Тайлант хугацаанд олон нийтийн газарт гарсан хэрэг өмнөх оны мөн үеэс 4(1.4%) хэргээр буурсан нийт олон нийтийн газарт гарсан хэргийн 78(28.6%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 50(18.3%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 145(53.1%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст тус тус бүртгэгдсэн байна.

ХҮСНЭГТ 9. ОЛОН НИЙТИЙН ГАЗАРТ ҮЙЛДЭГДСЭН ХЭРЭГ

Үзүүлэлт	Он	Олон нийтийн газар	Бөөний худалдааны төв	дэлгүүр	зочид буудал	баар	ресторан, зоогийн газар	Авто вокзал	Цайны газар
Сонгинохайрхан	2024.IX	277	19	38	53	59	5	20	16
I хэлтэс		134	10	16	22	32	3	10	7
II хэлтэс		35	3	9	5	5			1
III хэлтэс		108	6	13	26	22	2	10	8
Сонгинохайрхан	2025.IX	273	34	57	38	40	10	9	15
I хэлтэс		78	5	6	15	14	1	4	3
II хэлтэс		50	7	10	4	10	3	1	3
III хэлтэс		145	22	41	19	16	6	4	9
Өсөлт, бууралт хувь		-1.4	78.9	50.0	-28.3	-32.2	100.0	-55.0	-6.3


2025 оны сүүлийн 9 сард нийтийн тээвэрт 30 хэрэг гарсан нь өмнөх оноос 15(50.0%) хэргээр өссөн байна. Тайлан хугацаанд нийтийн тээвэрт гарсан гэмт хэргийн 6(20.0%) нь том оврын автобусанд, 14(46.7%) нь таксид, 7(23.3%) нь дунд оврын автобусанд тус тус үйлдэгдсэн байна. Таксид гарсан хэрэг өнгөрсөн оны мөн үеэс 14 дахин өссөн байна.

ХҮСНЭГТ 10. НИЙТИЙН ТЭЭВЭРТ ҮЙЛДЭГДСЭН ХЭРЭГ

Үзүүлэлт	Он	нийтийн тээвэр	том оврын автобус	дунд оврын автобус	такси
Сонгинохайрхан	2024.IX	15	4	10	1
I хэлтэс		10	3	6	1
II хэлтэс		2		2	
III хэлтэс		3	1	2	
Сонгинохайрхан	2025.IX	30	6	7	14
I хэлтэс		3	2		2
II хэлтэс		7	2	2	12
III хэлтэс		20	2	5	
Өсөлт, бууралт хувь		100.0	50.0	-30.0	14 дахин

2025 оны сүүлийн 9 сард нийтийн тээвэрт гарсан хэргийн 3(10.0%) цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 7(23.3%) цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 20(66.7%) цагдаагийн гуравдугаар хэлтэст тус тус бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 5. ХЭРЭГ ҮЙЛДЭГДСЭН БАЙРШИЛ, дүүргээр



2025 оны сүүлийн 9 сард Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн нийт хэргийн 259(7.4%) нь аж ахуйн нэгжид, 13(0.4%) нь төрийн байгууллагад, 7(0.2%) нь төрийн бус байгууллагад, 254(7.2%) нь авто зам дээр, 448(12.8%) бусад газарт тус тус гарсан байна. Тайлант хугацаанд аж ахуйн нэгжид гарсан хэргийн 93(35.9%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 71(27.4%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 95(36.7%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст гарсан байна. Төрийн байгууллагад гарсан хэрэг өнгөрсөн оны мөн үеэс 3(30.0%) хэргээр нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 11.

ХЭРЭГ ҮЙЛДЭГДСЭН ГАЗАР, өмчийн хэлбэрээр

Үзүүлэлт	Он	Төрийн байгууллага	Төрийн бус байгууллага	Аж ахуйн нэгж	Авто зам	Бусад
Сонгинохайрхан	2024.IX	10	12	186	149	451
I хэлтэс		5	6	101	83	304
II хэлтэс		2	2	35	42	112
III хэлтэс		3	4	50	24	35
Сонгинохайрхан	2025.IX	13	7	259	254	448
I хэлтэс		5	5	93	154	266
II хэлтэс		7		71	59	135
III хэлтэс		1	2	95	41	47
Өсөлт, бууралт хувь		30.0	-41.7	39.2	70.5	-0.7

2025 оны сүүлийн 9 сард хэрэг үйлдсэн хүний тоо 1883 байсан нь өмнөх оны мөн үеэс 560(42.3%) хүнээр өссөн байна. Хэрэг үйлдсэн нийт хүний 220(11.7%) нь эмэгтэй, 54(2.9%) нь 15 хүртэлх насны, 53(2.8%) нь 16-17 настай, 572(30.4%) нь 18-24 настай, 449(23.9%) нь 25-29 настай, 224(11.9%) нь 30-34 настай, 204(10.8%) нь 35-39 настай, 112(5.9%) нь 40-44 настай, 76(4.0%) нь 45-49 настай, 58(3.1%) 50-54 настай, 38(2.0%) нь 55-59 настай, 39(2.1%) нь 60 аас дээш настай байна. Хэрэг үйлдсэн эмэгтэйчүүдийн тоо өмнөх оноос 22(9.1%) хүнээр, 15 хүртэлх насны хүүхдийн тоо 31(36.5%) тус тус буурсан бол 18-24 настай 248(76.5%), 25-29 настай 275(2.6 дахин их), 60-аас дээш настай 18(85%) хүнээр тус тус намагдсан байна.

Тайлант хугацаанд хэрэг үйлдсэн нийт хүний 682(36.2%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 557(29.6%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 644(34.2%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст харъяалагдаж байна.

ХҮСНЭГТ 12.

ХЭРЭГ ҮЙЛДЭГСЭД, насны бүлгээр

Үзүүлэлт		Нийт											
Он		2024.IX	2025.IX	Өсөлт, бууралт хувь	I хэлтэс			II хэлтэс			III хэлтэс		
					2024.IX	2025.IX	Өсөлт, бууралт хувь	2024.IX	2025.IX	Өсөлт, бууралт хувь	2024.IX	2025.IX	Өсөлт, бууралт хувь
Бүх хүн		1 323	1 883	42.3	611	682	11.6	367	557	51.8	345	644	86.7
Эмэгтэй		242	220	-9.1	96	79	-17.7	89	79	-11.2	57	62	8.8
насны бүлэг	15 хүртэлх	85	54	-36.5	35	20	-42.9	17	16	-5.9	33	18	-45.5
	16-17	53	57	7.5	12	29	141.7	15	14	-6.7	26	14	-46.2
	18-24	324	572	76.5	109	119	9.2	123	90	-26.8	92	363	3.9 дахин их
	25-29	174	449	2.6 дахин их	90	106	17.8	37	274	640.5	47	69	46.8
	30-34	208	224	7.7	107	123	15.0	40	48	20.0	61	53	-13.1
	35-39	161	204	26.7	84	104	23.8	43	45	4.7	34	55	61.8
	40-44	118	112	-5.1	63	65	3.2	38	27	-28.9	17	20	17.6
	45-49	85	76	-10.6	45	37	-17.8	20	16	-20.0	20	23	15.0
	50-54	52	58	11.5	30	32	6.7	17	10	-41.2	5	16	220.0
	55-59	42	38	-9.5	25	24	-4.0	10	6	-40.0	7	8	14.3
	60-64	15	21	40.0	6	10	66.7	6	8	33.3	3	3	0.0
	65-69	5	14	2.8 дахин их	4	9	125.0	1	3	3 дахин их	0	2	2 дахин их
70+	1	4	4 дахин их	1	4	4 дахин их							

Оны сүүлийн 9 сарын байдлаар хэрэг үйлдсэн нийт хүний 19(1.0%) нь төрийн албан хаагч, 122(6.5%) нь хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч, 8(0.4%) нь төрийн бус байгууллагад ажиллагч, 416(22.1%) нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 7(0.4%) нь малчин, 25(1.3%) нь оюутан, 64(3.4%) нь сурагч, 11(0.6%) нь сургууль завсардсан буюу тэнэмэл хүүхэд, 2(0.1%) нь хоригдол, 1200(63.8%) нь ажилгүй иргэн байна. Тайлант хугацаанд хэрэг үйлдсэн ажилгүй иргэн өмнөх оны мөн үеэс 533(79.9%) хүнээр өссөн байна.

ХҮСНЭГТ 13. ХЭРЭГ ҮЙЛДЭГСЭД, НИЙГМИЙН БАЙДЛААР

Үзүүлэлт	Он	Төрийн албан хаагч	Хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч	Төрийн бус байгууллагын ажилтан	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	Малчин	Оюутан	Сурагч	Сургууль завсардсан хүүхэд, тэнэмэл хүүхэд	Хоригдол	Ажилгүй
Сонгинохайрхан	2024.IX	20	110	11	371	11	14	69	41	0	667
I хэлтэс		12	64	8	194	8	6	34	7		278
II хэлтэс		3	15	1	107	1	3	13	5		219
III хэлтэс		5	31	2	70	2	5	22	29		170
Сонгинохайрхан	2025.IX	19	122	8	416	7	25	64	11	2	1200
I хэлтэс		8	84	3	222	6	7	31	4		315
II хэлтэс		4	12	4	115		3	14	4	2	399
III хэлтэс		7	26	1	79	1	15	19	3		486
Өсөлт, бууралт хувь		-5.0	10.9	-27.3	12.1	-36.4	78.6	-7.2	-73.2	-	79.9

Хэрэг үйлдсэн нийт хүний 31(1.6%) нь боловсролгүй, 92(4.9%) нь бага боловсролтой, 199(10.6%) нь суурь боловсролтой, 1342(71.3%) нь бүрэн дунд боловсролтой, 58(3.1%) нь тусгай мэргэжилийн дунд боловсролтой, 161(8.56%) нь дээд боловсролтой байна.

ХҮСНЭГТ 14. ХЭРЭГ ҮЙЛДЭГСЭД, БОЛОВСРОЛЫН ТҮВШИНГЭЭР


Үзүүлэлт	Он	Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Тусгай мэргэжилийн дунд	Дээд
Сонгинохайрхан	2024.IX	42	46	176	850	49	120
I хэлтэс		9	7	86	375	31	63
II хэлтэс		6	16	37	278	11	19
III хэлтэс		27	23	53	197	7	38
Сонгинохайрхан	2025.IX	31	92	199	1342	58	161
I хэлтэс		15	32	82	436	34	83
II хэлтэс		4	24	67	415	18	29
III хэлтэс		12	36	50	491	6	49
Өсөлт, бууралт хувь		-26.2	2 дахин их	13.1	57.9	18.4	34.2

Тайлант хугацаанд гэмт хэргийн улмаас хохирсон 3294 иргэн байгаа нь өмнөх оны мөн үеэс 559(20.4%) хүнээр нэмэгдсэн бөгөөд 1372(41.7%) нь эмэгтэй байна. Гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн 117(3.6%) 13 хүртэлх насны хүүхэд, 119(3.6%) 14-17 насны, 273(8.3%) 18-24 насны, 319(9.7%) 25-29 насны, 405(12.3%) 30-34 насны, 624(18.9%) 35-39 насны, 478(14.5%) 40-44 насны, 330(10.0%) 45-49 насны, 261(7.9%) 50-54 насны, 168(5.1%) 55-59 насны, 200(6.1%) нь 60, түүнээс дээш насны хүн ам байна.

ХҮСНЭГТ 15. ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ХОХИРСОН ИРГЭН, насны бүлгээр

Үзүүлэлт		Нийт			I хэлтэс			II хэлтэс			III хэлтэс		
Он		2024.IX	2025.IX	Өсөлт, бууралт хувь	2024.IX	2025.IX	Өсөлт, бууралт хувь	2024.IX	2025.IX	Өсөлт, бууралт хувь	2024.IX	2025.IX	Өсөлт, бууралт хувь
Нийт хохирсон иргэн		2 735	3 294	20.4	1 428	1 247	-12.7	642	965	50.3	665	1 082	62.7
Эмэгтэй		1 197	1 372	14.6	589	500	-15.1	316	361	14.2	292	511	75
насны бүлэг	7 хүртлэх	18	22	22.2	7	11	57.1	8	7	-12.5	3	4	33.3
	8-13	74	95	28.4	38	44	15.8	15	26	73.3	21	25	19
	14-17	131	119	-9.2	64	50	-21.9	34	27	-20.6	33	42	27.3
	18-24	284	273	-3.9	155	111	-28.4	72	72	0	57	90	57.9
	25-29	300	319	6.3	157	126	-19.7	70	94	34.3	73	99	35.6
	30-34	415	405	-2.4	206	138	-33	93	122	31.2	116	145	25
	35-39	451	624	38.4	237	235	-0.8	107	201	87.9	107	188	75.7
	40-44	360	478	32.8	193	169	-12.4	87	143	64.4	80	166	2.1 дахин их
	45-49	263	330	25.5	141	117	-17	49	102	2.1 дахин их	73	111	52.1
	50-54	165	261	58.2	91	94	3.3	40	85	2.1 дахин их	34	82	2.4 дахин их
	55-59	122	168	37.7	63	69	9.5	28	40	42.9	31	59	90.3
	60-64	79	103	30.4	43	40	-7	18	26	44.4	18	37	105.6
	65-69	45	54	20	20	23	15	16	11	-31.3	9	20	2.2 дахин их
70 ба түүнээс дээш		28	43	53.6	13	20	53.8	5	9	80	10	14	40

ЗУРАГ 3. ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ХОХИРСОН ХҮН, цагдаагийн хэлтсээр



Тайлант хугацаанд гэмт хэргийн улмаас хохирсон нийт хүний 1247(37.9%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 965(29.3%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 1082(32.8%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст харъяалагдаж байна.

2025 оны сүүлийн 9 сард гарсан гэмт хэргийн улмаас 19325.1 сая төгрөгийн хохирол учирсан нь өнгөрсөн оны мөн үеэс 7817.2(67.9%) сая төгрөгөөр өссөн байна. Хөнгөн гэмт хэргийн улмаас учирсан хохирол 12988.8 сая төгрөг байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 5847.7(81.9%) сая төгрөгөөр, хүнд гэмт хэргийн улмаас учирсан хохирол 1969.2(45.1%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 16. ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ, сая төгрөгөөр

Үзүүлэлт	Он	Гэмт хэргийн улмаас учирсан хохирол / сая төгрөг/			хохирол нөхөн төлүүлэлт	
		хөнгөн	хүнд	сая төгрөг	хувиар	
Сонгинохайрхан	2024.IX	11 507.9	7 141.1	4 366.9	3 173.4	27.6
I хэлтэс		3 970.3	3 367.7	602.6	1 184.6	29.8
II хэлтэс		1 563.1	1 378.6	184.6	1 002.8	64.2
III хэлтэс		5 974.5	2 394.8	3 579.7	986	16.5
Сонгинохайрхан	2025.IX	19 325.1	12 988.8	6 336.1	5 153.6	26.7
I хэлтэс		12 032.8	6 787.0	5 245.8	2 086.6	17.3
II хэлтэс		2 159.5	1 821.7	337.7	986.1	45.7
III хэлтэс		5 132.8	4 380.1	752.6	2 080.9	40.5
Өсөлт, бууралт хувь		67.9	81.9	45.1	62.4	91.9

Тайлант хугацаанд 44494 зөрчил бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 5080(12.9%) зөрчлөөр нэмэгдсэн байна. Нийт бүртгэгдсэн зөрчлийн 43520(97.8%) нь шийдвэрлэсэн, 827(1.8%) нь баривчлуулсан байна.

ХҮСНЭГТ 17. БҮРТГЭГДСЭН ЗӨРЧЛИЙН ТОО, төрлөөр

Үзүүлэлт	Он	Нийт зөрчил	Шийдвэрлэсэн зөрчил		Баривчлуулсан
Сонгинохайрхан	2024.IX	39 414	38 872	1 213	
I хэлтэс		14 951	14 701	499	
II хэлтэс		9 942	9 757	311	
III хэлтэс		14 521	14 414	403	
Сонгинохайрхан	2025.IX	44 494	43 520	827	
I хэлтэс		16 974	16 370	260	
II хэлтэс		9 351	9 150	218	
III хэлтэс		18 169	18 000	349	
Өсөлт, бууралт хувь		12.9	12.0	-31.8	

Сонгинохайрхан дүүрэгт 2025 оны сүүлийн 9 сард гарсан нийт зөрчлийн 16974(38.1%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 9351(21.0%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 18169(40.9%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст тус тус бүртгэгдсэн байна.

*Сонгинохайрхан дүүргийн
статистикийн хэлтэст эмхэтгэн
гаргав.*

Статистик 

Мэдээ, мэдээлэл 

Номын сан 

Мэдлэгээ шалгах тоглоом 

Валютын ханш 









аппликейшнаас

СТАТИСТИКИЙН мэдээллээ аваарай

Data lab тооллого судалгааны микро мэдээллийн сан




Social network


www.facebook.com/StatisticMongolia/


www.twitter.com/statistic_mn

Лавлах утас



1900-1212

Цахим шуудан



information@nso.mn